



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/182

Мандалговь

Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд  
улсын үзлэг зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын 3 дугаар зүйл 3.2, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 4 дүгээр сарын 19-ны 01/1572 албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Сум хөгжүүлэх сан"-гийн эргэн төлөлтийн эх үүсвэрийг тогтвортой нэмэгдүүлэх, хөнгөлөлттэй зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, зээлийн давхардал үүсгэхгүй байх, тус сангийн болон бусад банк, санхүүгийн байгууллагын зээлийн эрсдэлийг бууруулах механизмыг бий болгох зорилготой улсын үзлэг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:


Ажлын хэсгийн дарга: Ц.Эрдэнэсүрэн (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: А.Ганбат (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)  
Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)  
Б.Түвшинбаяр (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Мөнхжаргал (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Хоёр. Сум хөгжүүлэх сангийн улсын үзлэгийг Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын батлан ирүүлсэн удирдамжийн дагуу 2019 оны 5 дугаар сарын 19-ний өдрөөс 6 дугаар сарын 1-ны өдрийн дотор аймгийн хэмжээнд чанартай зохион байгуулж мэдээллийг нэгтгэн, дүгнэлт хийж, үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (Ц.Эрдэнэсүрэн)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190491